ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 16 өдөр Дугаар А/95 Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөө аж ахуйн салбарын хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 10,000 (арван мянга) боодол нарийн ногоон өвсийг бүрдүүлсүгэй.

2.Нарийн ногоон өвс худалдан авахад шаардагдах 120,000,000 (нэг зуун хорин сая) төгрөгийг аймгийн гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Дээрх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Ганхуяг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА О.ПҮРЭВДОРЖ

2026 11 0201